

Хүүхдийн асрамж, эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой харьцуулсан судалгаа, тренд ба энэ төрлийн маргааныг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал

Доржтовоогийн БЯМБА-ОД*

Отгоны АНХБАЯР**

-
- I. Удиртгал
 - II. Харьцуулсан судалгаа
 - III. Монгол Улсын шүүхийн практик
 - IV. Дүгнэлт
 - V. Санал
-



* Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн Иргэний эрх зүйн секторын эрхлэгч, Төрийн удирдлагын магистр (МРА).

** Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн Иргэний эрх зүйн секторын судлаач, Хуульч.

Хүүхдийн асрамж, эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой харьцуулсан судалгаа, тренд ба энэ төрлийн маргааныг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал



Доржзовоогийн БЯМБА-ОД Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн Иргэний эрх зүйн секторын эрхлэгч, Төрийн удирдлагын магистр (МРА).

Отгоны АНХБАЯР

Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн Иргэний эрх зүйн секторын судлаач, Хуульч.

Хураангуй: Монгол Улсад Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 1 зүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тус тус зааснаар байгуулахаар болсон билээ.

Улмаар хуульд зааснаар тус шүүхийг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр байгуулахаар болсон¹ боловч эрх зүйн орчин, эдийн засаг, дэд бүтэц, хүний нөөц гэх мэт шалтгааны улмаас 2026 оны 3 дугаар сарыг хүртэлх байдлаар тухайн шүүх үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй байна.

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээр Хүүхдийн эрхийн тухай конвенц (Convention on the Rights of the Child), Гэр бүлийн тухай хууль (1999), Хүүхдийн эрхийн тухай хууль (2016)-д зохицуулагдсан "хүүхдийн асрамж, эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг"-тэй холбоотой Монгол Улсын эрх зүйн зохицуулалт болон шүүхийн практикийг судалсан. Түүнчлэн сэдвийн хүрээнд бусад улсын эрх зүйн зохицуулалт, түүний онцлог, цаашдын хөгжлийн чиг хандлага зэргийг тодорхойлон харьцуулж, энэ төрлийн маргааныг цаашид дагнасан шүүхээр шийдвэрлэхэд анхаарах асуудлыг тодорхойлж, дүгнэлт, санал дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг

Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх, хүүхдийн асрамж, тэжээн тэтгэх үүрэг, child custody, family court.

I. УДИРТГАЛ

Сэдвийн судлагдсан байдал, сонгосон үндэслэл

Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль (1999)-ийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт "Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдээ хэний асрамжид үлдээхийг ... харилцан тохиролцож болно", 14.6 дахь хэсэгт "... 14.5-д заасны дагуу

¹ Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйл.



тохиролцоогүй бол... хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх ... асуудлыг шүүх шийдвэрлэнэ" гэж, 26 дугаар зүйлийн 26.2.2 дахь заалтад "эцэг, эх хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүрэгтэй" гэж, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт "...эцэг, эх нь хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй", 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт "Эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй" гэж тус тус хуульчилсан.

"Хүүхдийн асрамж, эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг"-тэй холбоотой бичсэн Я.Батгэрэл судлаачийн "Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа, тулгамдсан асуудал" сэдэвт өгүүлэл, Б.Хонгорзул судлаачийн "Олон улсын гэрлэлтэд тулгарч буй тулгамдсан асуудал буюу олон улсын хүүхэд булаах иргэний хэргийн тухай Гаагийн конвенц" өгүүлэл, Хүний эрхийн үндэсний комиссоос гаргасан "Хагас болон бүтэн өнчин хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн асуудал" судалгааны тайлан, Шүүхийн академийн эмхэтгэн гаргасан "Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд Ж.Лхагвасүрэн, Г.Нямсүрэн нарын "Монгол Улс дахь хүүхдийн асрамжийн эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал" гэх өгүүлэл байх боловч хүүхдийн асрамжийн төрөл болон тэдгээрийн давуу сул талыг дэлгэрүүлэн тодорхойлсон, гадаад улсын шүүхийн практикийг нарийвчлан судалсан өгүүлэл, судалгаа, эмхэтгэл, нэг сэдэвт бүтээл байхгүй байна.

Иймд хүүхдийн асрамж, эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүргийн харилцаатай холбоотой бусад улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан, олон улсын хөгжлийн чиг хандлагыг дэлгэрүүлэн судалж энэхүү өгүүллээр авч үзсэн нь Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулан үйл ажиллагаа явуулж эхлэх цаг нэгэнт "хаяанд ирсэн" өнөөгийн нөхцөлд цаг үеэ олсон, онол, практикийн өндөр ач холбогдолтой гэж судлаачид үзлээ.

Судалгааны зорилго, шинэлэг тал

Энэхүү өгүүллээр хүүхдийн асрамж, эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийснээс гадна олон улсын түвшинд тухайн харилцаанд гарч буй өөрчлөлт, шинэчлэлтийн судалгааг хийж, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж дотоодын болон гадаад улсын шүүхийн практикаар баяжуулан судалснаараа шинэлэг талтай ба ач холбогдолтой билээ.

Судалгааны арга зүй

Эрдэм шинжилгээний өгүүллийг бичихдээ хууль зүйн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгддэг харьцуулан шинжлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглав.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хүүхдийн асрамжийг тогтоох хоёр үндсэн хэлбэр байх ба үүнийг нэг талын асрамж (sole custody) болон хамтапсан асрамж (joint custody) гэж ангилах ба Монгол Улсад "хүүхдийн асрамж" гэх албан ёсны хуулийн нэр томъёоны тодорхойлолт байхгүй байна. Гэсэн хэдий ч ойлголтыг Монгол Улсын



дээд шүүхийн 2017 оны Гэр бүлийн холбогдолтой эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудал гэх зөвлөмжид “эцэг, эхийн хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргийг хуваарилж байгаа асуудал биш, харин тусдаа амьдрах болсон эцэг, эхийн хэнтэй нь тухайн хүүхэд байнга оршин суухыг тодорхойлж, хүүхдийн амьдрах газрыг тогтоож байна гэсэн үг юм”² гэж тодорхойлжээ.

Харин тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаа гэж гэр бүлийн гишүүний аль нэг нь нөгөөдөө хуульд заасан журмын дагуу материаллаг тусламж үзүүлэхтэй холбогдсон гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн харилцааг хэлнэ гэж тодорхойлдог.

Тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаанд оролцогч субъектийг бүрэлдэхүүний хувьд эцэг, эх нь хүүхдээ, хүүхэд нь эцэг, эхээ, гэрлэгчид бие, биеэ, төрөл садангийн хүмүүс бие биеэ тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаа³ гэж ангилан үздэгээс энэхүү судалгааны хүрээнд хүүхдийн асрамжийн төрөл, эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэхтэй холбоотой хэсгийг бусад улсын эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикаас дэлгэрүүлэн судаллаа.

II. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Дээр дурдсанаар, “хүүхдийн асрамж” гэх ойлголтын хууль зүйн нэр томъёо бүрхэг, хуульд бүрэн тусгаагүй, шүүхийн практикаар нөхөн зохицуулсан шинжтэй боловч хүүхдийн асрамжийг тогтоож, тэтгэлэг гаргуулахтай холбоотой асуудал нь гэрлэгчдийн үндсэн маргаанд дарагдаж гэрлэлт цуцлалтыг дагалдаж үүсдэг дагавар асуудал болж байгаа⁴ явдал нь гэр бүлийн маргааныг “эрэмбэлсэн” шинжтэй болгож хүүхдийн асрамж тогтоохтой холбоотой маргааны хууль зүйн ач холбогдол, үр дагаврыг “үнэгүйдүүлэх” нөхцөл байдал үүсгэж байгаа нь “хүүхдийн дээд ашиг сонирхол (best interest of child)”-ыг хангах, хамгаалах олон улсын эрх зүйн ойлголт, зарчимд харшилж, сөргөөр нөлөөлж байна.

Дэлхий дахинаа хүүхдийн асрамж, тэжээн тэтгэхтэй холбоотой харилцаанд “хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах” зарчим үйлчилдэг хэдий ч улс орон бүр, тэр дундаа муж улс бүр энэхүү зарчмыг хэрхэн тайлбарлаж хэрэглэж байгаа нь ялгаатай байдаг байна⁵. Тодруулбал, гэрлэгчид гэрлэлтээ цуцлах тохиолдолд хэд хэдэн хууль зүйн үр дагавар үүсгэх шийдвэрийг эцэг, эх харилцан тохироогүй бол шүүхээс шийдвэрлэх шаардлагатай болдог гэж үздэг. Үүнд: хүүхэд хаана амьдрах (бие махбодын асрамж буюу “physical custody”), хүүхдэд хамаарах нэн чухал шийдвэр (major decisions) гаргах эрхийг хэн хэрэгжүүлэх (хууль ёсны асрамж буюу “legal custody”), хүүхдэд ногдох хөрөнгийг хэрхэн хуваах, хүүхдийн тэтгэлгийг хэрхэх гэх мэт асуудал хамаарна⁶. Үүнээс хүүхдийн асрамж

² Шүүхийн академи, “Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл”, 2025, 77-79 дэх тал.

³ Хууль зүй, дотоод хэргийн яам, “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл, Гэр бүлийн эрх зүй /гарын авлага/, 2007, 73 дахь тал.

⁴ Шүүхийн академи, өмнөх эшлэл 2, 41 дэх тал.

⁵ Jeff Atkinson, “Custody: It all comes down to the best interest of the child”, Family Advocate, Vol. 12, No. 3, 34, 1990. <https://www.jstor.org/stable/25804756>.

⁶ Maria Cancian, Daniel R. Meyer, “Who Gets Custody?”, Demography, Vol. 35, No. 2, 148, 1998. <https://www.jstor.org/stable/2086000>.



гэдэг нь бие махбодын асрамж болон хууль ёсны асрамжаас бүрдэнэ гэж үзэх боломжтой билээ.

Монгол Улсын хувьд мөн адил гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлахад гэр бүлийн дундын хөрөнгөөс өөрт ногдох хэсгийг гаргуулах, хүүхдийн асрамж тогтоох, тэтгэлэг гаргуулах гэх мэт асуудлыг шийдвэрлэдэг хэдий ч "бие махбодын асрамж", "хууль ёсны асрамж", "шийдвэр гаргах үүрэг" эсхүл "эцэг, эхтэй өнгөрүүлэх цаг" гэх зэрэг асуудлыг тус бүрд нь хуульд "детальчлан" зохицуулаагүйгээс гагцхүү "эцэг, эх хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүрэг"-ийн хүрээнд ерөнхий, тойм байдлаар зохицуулсан хэм хэмжээнд үндэслэж байна.

Иймээс Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэх маргаан дагнасан шүүх байгуулснаар улам бүр өсөн нэмэгдэх⁷ хандлагатай байгаа⁸, цаашилбал энэхүү харилцаа нь өөрийн гэсэн онцлог бүхий процесстой, бие даасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болж байгаа тул Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зохицуулах, шүүхээс энэ төрлийн маргааныг шийдвэрлэхдээ хүүхдийн асрамж, эцэг эх хүүхдээ тэжээн тэтгэхтэй холбоотой ойлголтыг анхаарах, дэлгэрүүлэн судлах зайлшгүй шаардлагатай гэж үзэн дараах гадаад улсыг судаллаа.

1. Америкийн Нэгдсэн Улс

Америкийн Нэгдсэн Улс (цаашид "АНУ" гэх)-ыг сонгон харьцуулан судалсан шалтгаан нь, тус улс нь дэлхийд "хамгийн ихээр гэрлэлт цуцлуулдаг 100 улс"-аас 19 дүгээр байрт эрэмбэлэгддэг⁹ тул хүн амын тоо, гэрлэлт цуцлалтын хувь хэмжээ нь "өндөр" улс бөгөөд тэр хэмжээгээрээ гэр бүлийн эрх зүйд холбогдох маргаан их гардаг, энэ төрлийн маргааныг шийдвэрлэх шүүхийн практик буюу прецедент төлөвшсөн улс гэж үзэн сонгосон болно.

АНУ-ын эрх зүйн зохицуулалтын түүх, түүний философиос үзвэл, эхэн үедээ эцгийн давуу эрх үйлчилдэг байсан бол явцдаа эхийн давуу эрх үйлчлэх болж улмаар хамтарсан асрамж (joint custody) гэх ойлголтыг хэрэглэх болжээ¹⁰. Тодруулбал, 19 дүгээр зуунаас өмнө, колоничлолын үед жишгийн эрх зүйн системээр хөгжиж, хүүхдийг эцгийн "өмч" хэмээн үздэг байснаас хүүхдийн асрамжийг эцэгт үлдээх нь түгээмэл байсан бол 1800-аад оноос эхлэн "зөөлөн номлол" (tender years doctrine) цэцэглэн хөгжжээ. Тус номлолоор хүүхдийн хувьд эх нь түүнийг илүү сайн анхааран халамжлагч, асран хамгаалагч байх болно

www.jstor.org/stable/3004048.

⁷ Монгол Улсын дээд шүүхийн 2007 оны 12 сарын 17-ны өдрийн Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай зөвлөмж, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231249493301>.

⁸ Монгол Улсын дээд шүүхийн цахим хуудас, "2024 онд иргэний хэргийн шүүхүүд 70 мянган хэрэг шийдсэнээс 6300 орчим нь гэр бүлийн хэрэг байна. Шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй иргэний хэргийн 7-8 хувийг гэр бүлийн хэрэг эзэлдэг. Гэхдээ энэ тоо жил бүр өссөөр байна." <https://www.supremecourt.mn/en/home?page=pages&id=58&pg=3638&pr=14&tp=list&h=0>.

⁹ "Data analysts on World Divorce Rates: Ranking of countries from highest to lowest risk of getting divorced", <https://news.cision.com/abcd-agency-ug/r/data-analysts-on-world-divorce-rates-ranking-of-countries-from-highest-to-lowest-risk-of-getting-divorced>, c3747396 (last visited: 2026.03.20).


¹⁰ Mary Ann Mason, From Fathers' Property to Children's Rights: A History of Child Custody, University of California, Berkeley School of Law, (1994) <https://www.law.berkeley.edu/our-faculty/faculty-sites/mary-ann-mason/books/from-fathers-property-to-childrens-rights-a-history-of-child-custody/> (last visited: 2026.03.20).

гэж номлодог ба үүнээс үүдэн 20 дугаар зуун гэхэд дийлэнхдээ хүүхдийг эхийн асрамжид үлдээн шийдвэрлэдэг болсон байна. 1960-аад оныг хүртэл ноёрхсон энэхүү номлолын дараа АНУ-ын муж улсууд хүүхдийг асран хамгаалах тухай хуульдаа аль нэг хүйсийн давуу эрхийг хасаж эхэлсэн байдаг.¹¹

Одоо мөрдөгдөж буй АНУ-ын хууль тогтоомжид заасан түгээмэл үзэл, хандлага нь "хүүхдийн дээд ашиг сонирхол" буюу "best interest of the child"-д тулгуурласан байхаас гадна 21 дүгээр зуун гарсаар тодорхой хугацаагаар хүүхэд нь эцэг болон эхтэйгээ хамт амьдрах буюу бие махбодын асрамж (physical custody)-ийн тухай ойлголт дэлгэрэх болсон байна.¹² Түүний нэгэн жишээ нь 1980 оны үед гэрлэлт цуцлахад хүүхдийг хамтарсан асрамж (joint custody)-д үлдээхээр шийдвэрлэж байсан маргаан 13 хувь байсан бол 2010 оны үед энэ тоо 34 хувь болж өссөнтэй¹³ холбогдоно.

АНУ-ын ихэнх муж улсад тэгш хамгаалалтын үзэл баримтлал орших ба энэ нь хүүхдийн асрамжийг өөртөө авахаар эцэг, эх хэн аль нь хүсэлт гаргах тэгш эрхтэй, хүүхдийн асрамжийг аль нэг хүйст давуу байдал олгох байдлаар тогтоох ёсгүй гэсэн утгатай. Мөн зарим муж улсад "хүүхдийн асрамж" буюу "custody" гэх нэр томъёог өөрчлөн шинэ чиг хандлагыг тогтоогоод байна. Жишээлбэл: Аризона мужид бие махбодын асрамж буюу "physical custody" гэх эцэг, эх хүүхэдтэйгээ биечлэн өнгөрүүлэх цаг хугацаа гэх агуулгатай нэр томъёог одоо "эцэг, эхтэй өнгөрүүлэх цаг" буюу "parenting time" болгож өөрчилсөн, хууль ёсны асрамж буюу "legal custody" гэх шийдвэр гаргах эрх гэх утгатай нэр томъёог одоо "шийдвэр гаргах эрх" буюу "decision-making authority" хэмээн өөрчилж хэрэглэж байна.¹⁴ Үүнийг дараах байдлаар харуулбал:

Схем 1. Хүүхдийн асрамжтай холбоотой нэр томъёоны шинэчлэл



Энэ нь Канад Улсад ч мөн адил буюу 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс Гэрлэлт цуцлалтын тухай хууль (Divorce Act)-ийн "асрамж ба уулзалт (custody and access)" гэх нэр томъёог "шийдвэр гаргах үүрэг (decision-making responsibility) ба эцэг, эхтэй өнгөрүүлэх цаг (parenting time) гэх нэр томъёогоор илэрхийлж эхэлсэн ба "асрамж" гэдэгт дээрх хоёрыг хамтад нь ойлгох бол "уулзалт" гэдэгт цор ганц эцэг, эхтэй өнгөрүүлэх цагийг ойлгохоор¹⁵ болжээ.

¹¹ supra note 6.

¹² Barb Lightner, "Child Custody", (2025), <https://www.ebsco.com/research-starters/law/child-custody> (last visited Mar.17, 2026).

¹³ Ibid.

¹⁴ Ibid.

¹⁵ Government of Canada, Changes to the Divorce Act Explained, <https://www.justice.gc.ca/eng/fl-df/educators-educateurs.html> (last visited Mar.23, 2026).



Дээрхээс дүгнэвэл, АНУ-д гэрлэлт цуцалсан тохиолдолд хүүхдийг эцэг, эхийн хамтарсан асрамж (joint custody)-д үлдээхээс гадна хүүхдийг асрамждаа авахаар эцэг, эх хүсэлт гаргах тэгш эрхтэй байх, хүйсээс үл хамааран давуу байдал эдэлдэггүй байна. Түүнчлэн зарим муж улсад нэр томъёоны шинэчлэл хийн "бие махбодын" эсхүл "хууль ёсны асрамж" гэх нэр томъёог "эцэг, эхтэй өнгөрүүлэх цаг", "шийдвэр гаргах эрх" гэсэн шинэ нэр томъёогоор хуульчлан зохицуулах болжээ.

Ийнхүү эрх зүйн ойлголтын агуулгыг эрх зүйн хөгжил, шинэчлэлтэй уялдуулан, нарийвчилсан байдлаар зохицуулах нь эцэг, эхийг "үүрэгжүүлэх"-д эерэг нөлөөтэй боловч хамтарсан асрамжийн хувьд "хамтран" шийдвэр гаргах буюу эцэг, эх зөвшилцөлд хүрэх процесс тийм ч амар хялбар биш тул "цаг алдах эрсдэл" үүсэж болзошгүй байдаг. Энэ нь хамтарсан асрамжийн хэлбэрийн сөрөг тал ба хүүхдийн дээд ашиг сонирхол хөндөгдөх, зөрчигдөх нөхцөл болдог. Холбогдох шүүхийн шийдвэрээс жишээ дурдвал:

Тохиолдол 1. АНУ-ын Виржиниа мужийн Дээд шүүхийн шийдвэр¹⁶

Дэвид Роу (эцэг), Катерин Роу (эх) нар 1976 онд гэрлэлтээ цуцлуулжээ. Тэд 1 охинтой ба охин нь эхийнхээ асрамжид байдаг байсан. 1979 онд охины ээж хорт хавдар өвчнөөр оношлогдсоноор хүүхдээ асрамжлах чадамгүй болж охиныг эцгийн асрамжид шилжүүлсэн боловч хорт хавдар нь бүрэн эдгэрсний дараа ээж нь охиныг өөрийг асрамжид авахаар хүсэлт гаргасан. Учир нь, охины аав ижил хүйсийн хүнээ сонирхох бэлгийн чиг баримжаатай болсон байх ба тэд охинтой нь хамт амьдарч байсныг мэдсэн, охин нь ээжтэйгээ амьдрах хүсэл зоригтой байгаагаа илэрхийлсэн гэжээ.

Анхан шатын шүүхээс охиныг эцэг, эхийн хамтын асрамжид үлдээж шийдвэрлэсэн ба хичээлийн жилийн үед охиныг аав нь асран хамгаалах, зуны улиралд ээж нь асран хамгаалахаар захирамжилж, аав нь охиныг хамт байх үед хамтрагчтайгаа унтлагын өрөөгөө хуваахгүй байхыг даалгасан байна. Ээж нь энэхүү шийдвэрт давж заалдах гомдол гаргасан тул Дээд шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийн хүчингүй болгон, **"хүүхдийг асран хамгаалах шийдвэр нь хүүхдийн сайн сайхан байдлыг нэн тэргүүнд тавих ёстой иймээс эцэг, эх нь хүүхдийнхээ дэргэд ижил хүйсийн хүнтэй нээлттэйгээр хамтран амьдарч байгаа нь хүүхдийн дээд ашиг сонирхол буюу best interest of the child-д нийцэхгүй, хүүхэд өсөж бойжиход түүнийг хүрээлж буй ёс суртахууны орчин чухал нөлөөтэй ба ижил хүйсийн хүмүүс, нэн ялангуяа аав нь ижил хүйсийнхээ хүнтэй хамтран амьдарч байгааг харах нь хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх боломжтой тул эцгийн нь хамтын амьдралын харилцаа хүүхдийн хөгжил, нийгэмшилд сөргөөр нөлөөлж болзошгүй"** гэж үзэж асрамжийг ээжид нь үлдээж буюу хүүхдийг нэг талын асрамжид үлдээн шийдвэрлэжээ.

¹⁶ Roe v. Roe (1985) <https://law.justia.com/cases/virginia/supreme-court/1985/832044-1.html> (last visited Mar.20, 2026).



Тохиолдол 2. АНУ-ын Аризона мужийн
Давж заалдах шатны шүүхийн шийдвэр¹⁷

Жералд Ромин (эцэг), Паола Жордан (эх) нар 2005 онд гэрлэлтээ цуцлуулжээ. Тэд 2 хүүхэдтэй ба гэрлэлтээ цуцлуулахад 2 хүүхдийг эцэг, эхийн хамтын асрамжид үлдээж шийдвэрлэсэн. 2 хүүхэд нь хувийн шашны цэцэрлэг, сургуульд суралцдаг байсан ба аав нь хожим хүүхдүүдээ шашны хувийн сургуульд суралцахыг эсэргүүцэж, ээж нь анхан шатны шүүхэд хандан гомдол гаргажээ. Шүүхээс "эцэг, эх нь хоёул хүүхдийн боловсролын талаар нэн чухал шийдвэрийг хамтран гаргах ёстой. хамтын асрамжид байгаа хүүхдийн талаар эцэг, эх зөвшилцөлд хүрээгүй буюу энэ тохиолдолд эцэг нь хүүхдүүдийг хувийн шашны сургуульд сургахыг зөвшөөрөөгүй бол хүүхдүүд нь үргэлжлүүлэн суралцах боломжгүй" гэжээ. Тус шийдвэрийг эсэргүүцэж хүүхдүүдийн ээж давж заалдах гомдол гаргасан ба Аризона Мужийн Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, **"хамтын асрамжид байгаа хүүхдийн талаар эцэг, эх тохиролцоонд хүрч чадахгүй бол шүүхээс цаг алдалгүй "хүүхдийн дээд ашиг сонирхол буюу best interest of the child" зарчмын баримтлан шийдвэр гаргана."** гэж шийдвэрлэжээ.¹⁸

Дурдсан АНУ-ын шүүхийн практикаас үзвэл, хамтарсан асрамж нь хүүхэд эцэг, эхтэйгээ тэнцвэртэй харилцах буюу ижил цагийг хамт өнгөрүүлэх боломж бүрдүүлсэн, энэ нь хүүхдийн өсөлт, хөгжилд эергээр нөлөөлөх, эцэг, эхийн хэн аль нь хүүхдийнхээ хувьд нэн чухал шийдвэр гаргахад хамтран оролцох боломжтой, жендерийн тэгш байдлыг хангах талаар давуу тал олгодог асрамжийн хэлбэр боловч зарим талаараа сөрөг үр дагавар үүсгэх боломжтой болох нь батлагдаж байна. Үүнд: эцэг, эх нь зөвшилцөл, тохиролцоонд хүрээгүй бол хүүхдийн дээд ашиг сонирхол хөндөгдөх, эцэг, эхийн зөрчлөөс үүдэн хүүхдийн өсөлт, хөгжилд сөрөг үр дагавар илрэх, эцгийн оршин суугаа газар болон эхийн оршин суугаа газар алслагдмал буюу бие биеэсээ хэт хол бол хүүхдийн бие, сэтгэл зүйд хүндрэл учрах гэх мэт. Иймд хамтарсан асрамжаас үүссэн хүүхдийн дээд ашиг сонирхол хөндөгдсөн, зөрчигдсөн тохиолдолд шүүх нэн даруй оролцож хүүхэд хамгааллын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хүүхдийг нэг талын асрамжид үлдээн шийдвэрлэх нь чухал юм.

Мөн АНУ-ын хүүхдийн асрамж, тэжээн тэтгэхтэй холбоотой хуулийн үзэл баримтлал, чиг хандлага нь Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд зохицуулснаас эрс ялгаатай байна гэж үзсэн. Учир нь, Монгол Улсын хууль тогтоомжид хамтарсан асрамж бус нэг талын асрамж (sole custody)-ийг хуульчлан зохицуулсан төдийгүй шүүхийн практикт гэрлэлт цуцлахад хүүхдийг нэг талын асрамжид үлдээн шийдвэрлэх хандлага төлөвшсөн гэж үзэх боломжтой. Иймд нэг талын асрамжийн талаар дэлгэрүүлэн судалъя.

2. Япон Улс

Тус улсын хувьд гэрлэлт цуцлалтын дийлэнхийг үл маргах журмаар шийдвэрлэдэг¹⁹, гэрлэлт цуцлалт харьцангуй дундаж буюу үндэсний гэрлэлт

¹⁷ Jordan v. Rea (2009) <https://caselaw.findlaw.com/court/az-court-of-appeals/1256201.html> (last visited Mar.20, 2026).

¹⁸ Civil Code of Japan (1896), art. 766.1.

¹⁹ Шүүхийн академи, өмнөх эшлэл 2, 41 дэх тал.



цуцлалтын түвшин (national divorce rate)-ээрээ Монгол Улстай төстэй²⁰ төдийгүй түүхэн цаг үеийн явцад нэг талын асрамжийг дэмжин хуульчилж зохицуулж байсан боловч 2026 оноос өөрчлөлт оруулахаар зэхэж байгаа улс тул харьцуулан судлахаар сонгосон болно.

Япон Улсын Иргэний хууль (Civil Code)-ийн 766 дугаар зүйл болон 819 дүгээр зүйлүүдэд тус тус гэрлэлт цуцалсны дараах хүүхдийн асрамж, тэжээн тэтгэхтэй холбоотой харилцааг хэрхэх талаар хуульчилжээ. Тухайлбал, гэрлэгчид харилцан тохиролцон гэрлэлтээ цуцалсан бол хүүхдийн асрамж, хүүхэдтэй уулзах болон бусад байдлаар харилцах, тэтгэлгийн хэмжээний талаар талууд шийдвэр гаргана, ингэхдээ хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавина²¹, хэрэв гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулахаас өмнө дурдсан асуудлын талаар тохиролцоонд хүрээгүй бол Гэр бүлийн шүүх (Family Court) тухайн асуудлыг шийдвэрлэнэ²² хэмээн зохицуулсан байгаагаас гэрлэлт цуцалсны дараа тухайн хүүхэд эцэг, эсхүл эхийн аль нэгийн асрамжид шилжин²³ (ихэнх тохиолдолд хамгийн сүүлд буюу хүүхдийг асран халамжлахад хамгийн их үүрэгтэй байсан эцэг эсхүл эх) нөгөө эцэг эсхүл эх нь хязгаарлагдмал эрх мэдэлтэй үлддэг байна. Үүнийг "тасралтгүй байх зарчим" буюу "continuity principle" гэнэ²⁴. Түүнчлэн хуулийн 819 дүгээр зүйлд "гэрлэгчид харилцан тохиролцон гэрлэлтээ цуцалсан тохиолдолд, хэн нь эцэг, эхийн эрх мэдлээ (parental authority) авч үлдэхээ шийдвэрлэх ёстой, шүүхийн журмаар гэрлэлт цуцалсан бол уг асуудлыг шүүх шийдвэрлэнэ²⁵" гэж хуульчилжээ. Үүнээс үзвэл, Япон Улсад гэрлэлт цуцалсны дараа хүүхдийн асрамжийг эцэг эсхүл эхийн хэн нэгэнд үлдээж, эцэг, эхийн аль алинд хүүхдийг тэжээн тэтгэх үүргийг хэвээр хадгалж үлдээдэг буюу нэг талын асрамж хэрэгждэг байна.

Хэдий тийм боловч энэ онд буюу 2026 оны 4 дүгээр сараас хэрэгжиж эхэлж байгаа нэгэн онцлог зохицуулалт нь Япон Улсад хамтарсан асрамжийг хүлээн зөвшөөрсөн²⁶ явдал байна. 2024 оны 5 дугаар сарын 17-нд Иргэний хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр²⁷ гэрлэгчид гэрлэлтээ цуцлахдаа хамтарсан эсхүл нэг талын асрамжийг сонгох боломжтой болно гэсэн үг юм. Хамтарсан асрамжийн хувьд АНУ-ын нэгэн адил нэн чухал шийдвэрүүдийг эцэг, эх харилцан зөвшилцөж гаргах, өдөр тутмын амьдралын (day-to-day matters) шийдвэрийг хүүхдийг асрамждаа байлгаж буй эцэг эсхүл эх гаргах бол нэг талын асрамжийг сонгох тохиолдолд хүүхдийн асрамж гагцхүү эцэг эсхүл эхэд үлдэж, нөгөө нь

²⁰ supra note 9. Япон Улсад 35% бол Монгол Улсад 32% байна.

²¹ supra note 18, art. 766.2.

²² supra note 18, art. 819.1.

²³ Шүүхийн академи, өмнөх эшлэл 2, 42 дахь тал.

²⁴ From Sole to Shared: Unpacking Japan's Exclusive Custody Laws and the Emerging Shift Towards Joint Custody, [https://www.durhamasianlawjournal.com/post/from-sole-to-shared-unpacking-japan-s-exclusive-custody-laws-and-the-emerging-shift-towards-joint-c#:~:text=This%20discretion%20is%20underpinned%20by%20the%20principle,the%20child's%20settled%20status%20in%20one%20household.\(last%20visited%20Mar.23,%202026\).](https://www.durhamasianlawjournal.com/post/from-sole-to-shared-unpacking-japan-s-exclusive-custody-laws-and-the-emerging-shift-towards-joint-c#:~:text=This%20discretion%20is%20underpinned%20by%20the%20principle,the%20child's%20settled%20status%20in%20one%20household.(last%20visited%20Mar.23,%202026).)

²⁵ supra note 18, art. 819.2.

²⁶ "Key Family Policy Changes in Japan in 2026", [https://savvytokyo.com/key-family-policy-changes-in-japan-in-2026/#:~:text=From%20April%202026%2C%20Japan%20will,limited%20say%20in%20major%20decisions.\(last%20visited%20Mar.23,%202026\).](https://savvytokyo.com/key-family-policy-changes-in-japan-in-2026/#:~:text=From%20April%202026%2C%20Japan%20will,limited%20say%20in%20major%20decisions.(last%20visited%20Mar.23,%202026).)

²⁷ "Introduction of Joint Custody: The Background to the Quick Passage of the Revised Civil Code" [https://www.japanpolicyforum.jp/society/pt2024080709180714546.html#:~:text=On%20May%2017%2C%202024%2C%20the,%5B%E2%80%A6%5D\(last%20visited%20Mar.23,%202026\).](https://www.japanpolicyforum.jp/society/pt2024080709180714546.html#:~:text=On%20May%2017%2C%202024%2C%20the,%5B%E2%80%A6%5D(last%20visited%20Mar.23,%202026).)



хязгаарлагдмал эрх мэдэлтэй гэсэн үг болно²⁸.

Ийнхүү сонгох боломж олгож байгаа шинэчилсэн зохицуулалтын онцлог нь, хүүхдийн дээд ашиг сонирхолд ээлтэй гэж үзвэл эцэг, эх харилцан тохирсон эсэхээс үл хамааран Гэр бүлийн шүүхээс хүүхдийг хамтарсан асрамжид үлдээхээр шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн, мөн "яаралтай шийдвэр" гаргах зайлшгүй шаардлагатай тохиолдол (жишээлбэл: сургуульд элсэх, эмнэлгийн тусламж авах, хүчирхийлэлд өртөх гэх мэт)-д цаг алдалгүй нэг талын шийдвэр гаргах эрх олгох зэрэг давуу талтай, уян хатан систем болно²⁹ гэж тайлбарласан. Энэхүү эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шүүмжлэгч нарын санааг зовоож байгаа асуудал нь тус зохицуулалтын практик хэрэглээ буюу эцэг, эх харилцан зөвшилцөөгүй үед ч хамтарсан асрамжийг шүүхээс тогтоох боломж олгосон, өмнө нь гэрлэлтээ цуцлуулсан ба хүүхэд нэг талын асрамжид байгаа тохиолдлын асуудал дахин сөхөгдөнө гэж үзэж байгаагаас гадна "яаралтай шийдвэр" гэдэгт юуг ойлгох нь тодорхойгүй байгаа явдал болно³⁰.

Япон Улсын хүүхдийн асрамжтай холбоотой шүүхийн практикаас дурдвал:

Тохиолдол 3. Осакагийн Дээд шатны шүүхийн шийдвэр³¹

АНУ-ын Висконсин мужид амьдардаг эмч Мойсес Гарсиа охин Каринагийнхаа асрамжтай холбогдуулан Япон Улсын шүүхэд 4 жил маргасны эцэст охины асрамжийг өөр дээрээ үлдээжээ.

Гарсиа 350,000 орчим доллар зарцуулж, Япон руу олон удаа аялж, япон хэл сурч, охинтойгоо холбоо тогтоохын тулд хоёр улсын эрх баригчдаас тусламж хүсэж, маргааны үеэр охинтойгоо ердөө 3 удаа уулзжээ. Японы шүүх эцэст нь түүнд охинтойгоо уулзах эрх олгож шийдвэрлэсэн боловч түүний хуучин эхнэрийг 2011 онд хүүхэд хулгайлсан хэргээр Хавайд баривчилсны дараа л энэ хэрэг шийдэгдсэн бөгөөд үүний үр дүнд Карина АНУ руу аав дээрээ очсон байна.

Осакагийн Дээд шатны шүүх хүүхдийг Япон Улсад үлдээх нь хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэхгүй хэмээн үзэж хэдий ховор тохиох боловч хил-дамнасан хүүхдийн асрамжтай холбоотой маргааныг Японы эрх зүйн системийн дагуу шийдвэрлэсэн хэрэг болсон гэж үздэг.

²⁸ supra note 26.

²⁹ "Joint Custody Will Begin in Japan from April 2026" <https://nejihashi.com/en/japan-joint-custody-2026/>

³⁰ supra note 26.

³¹ American father wins custody of child after divorce from Japanese woman, <https://japantoday.com/category/national/american-father-wins-custody-of-child-after-divorce-from-japanese-woman> (last visited Mar.24, 2026).



Тохиолдол 4. Токиогийн Гэр бүлийн шүүхийн
2022 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн шийдвэр³²

Япон Улсын иргэн (эхнэр), Бүгд Найрамдах Франц Улсын иргэн (нөхөр)-ээс гэрлэлтээ цуцлуулахаар шүүхэд хандсан ба шүүхээс **гэрлэлт цуцалж хүүхдийг эхийн асрамжид үлдээн шийдвэрлэжээ**. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эх нь хүүхдээ аван оршин байгаа газраа орхин явах нь "хүүхдийг хулгайлсан явдал биш" хэмээн үзэж **тасралтгүй байх зарчим (continuity principle)-ын дагуу хүүхдийн эхийг тухайн хүүхдийн үндсэн асрамжлагч (primary caregiver) байсан гэж үзэж хүүхдийг нэг талын асрамжид үлдээсэн**.

Дээрхээс үзвэл, Япон Улсын хувьд нэг талын асрамж буюу хүүхдийн ээнэгшин дассан байдал, хүүхдийг өсөн торниход үндсэн үүрэгтэйгээр оролцсон этгээдийн нөлөөллийг харгалзан тухайн хүүхдэд "тухтай" байх этгээдийг буюу эцэг, эхийн зөвхөн нэгний асрамжид хүүхдийг үлдээж шийдвэрлэдэг байна. Энэ нь хүүхдийн асрамж "тасралтгүй байх" зарчмыг хэрэгжүүлж байгаа гэсэн үг юм.

Хүүхдийг нэг талын асрамжид үлдээх загвар нь хүүхэдтэй холбоотой шийдвэрийг хүүхдийг асрамждаа байлгаж байгаа эцэг эсхүл эх бие даан гаргах тул цаг хугацааны хувьд "түргэн" шийдэх боломжтой, хүүхдийн хувьд харьцангуй "тогтвортой" орчин үүсгэж, хүүхэд хамгааллыг түүний асран хамгаалагч цаг алдалгүй хэрэгжүүлэх боломжтой гэх мэт давуу талтай.

Хэдий тийм боловч хүүхдийг асрамждаа аваагүй эцэг эсхүл эхийн хувьд хязгаарлагдмал эрх эдлэх, хүүхэдтэй уулзах цаг хомсодсоноос хүүхэдтэй харилцах харилцаанд сөргөөр нөлөөлөх, хүүхдийг асрамждаа авсан талд санхүүгийн дарамт нэмэгдэх гэх мэт сөрөг үр дагавартай байна. Энэхүү сөрөг үр дагаврууд Монгол Улсын шүүхийн практикт мөн адил тулгамдсан асуудал болоод байгаа ба Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийг дагнан байгуулах тохиолдолд үүсэж болох асуудлыг дараах хэсэгт тоймлон авч үзлээ.

III. МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ПРАКТИК³³

Гэр бүлийн харилцаа дуусгавар болох эсхүл хамтран амьдрагч нар тусдаа амьдрах үед тэдний дундаас төрсөн болон үрчлэгдсэн хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэх шаардлага үүснэ. Түүхэн зохицуулалтаас үзвэл БНМАУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын 1961 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 2/11 тоот тогтоолд "Эцэг, эхээс хоорондоо марган булаалцалдаж байгаа хүүхдийг эцэг, эхийн алины асрамжид байлгахад хүүхдийн эрх ашигт тохирохыг Иргэний байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар хүүхдийн эх, эмч, хүүхдийг сурган хүмүүжүүлэх мэргэжлийн хүмүүсээр бүрдсэн экспертизийг шүүхийн магадлалаар томилж экспертизийн шинжилгээ дүгнэлт, саналыг гаргуулан

³² Regarding the Tokyo Family Court's divorce lawsuit judgment dated July 7, 2022, https://note.com/kyodo_shinpai/n/n634d7742c695 (last visited Mar.24, 2026).

³³ Шүүхийн шийдвэрийн цахим санд байршсан "Гэр бүлийн холбогдолтой" шийдвэрүүдийн дийлэнх нь нууцлалтай эсхүл "Тогтоох" хэсэг нь л нийтэд нээлттэй байршсан байх тул судлаачид гагцхүү нээлттэй эх сурвалжийн хүрээнд мэдээлэл цуглуулах боломжтой байсан, шүүхийн архиваас мэдээлэл цуглуулах боломжгүй байсныг дурдъя.



шийдвэрлэнэ"³⁴ хэмээн зохицуулснаас үзэхэд ямар ч тохиолдолд хүүхдийн эрх ашгийг хамгаалах бодлого хэрэгжиж байсан нь харагдана.

Монгол Улсын нэгдэн орсон Хүүхдийн эрхийн тухай 1989 оны конвенцод "Нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна"³⁵ гэж заасан. Дээрх тогтоол болон конвенцод зааснаар шүүх хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд эцэг, эхийн хэн нь хүүхдээ асран хүмүүжүүлэхэд илүү анхаарал тавьж халамжилдаг, хүүхдийн насны онцлог, цаашдын хүмүүжилд нөлөөлөх байдал, эцэг, эхийн хувийн зан чанар, хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх нөхцөл байдлыг хангах боломж зэргийг тал бүрээс нь нарийвчлан тогтоох нь ихээхэн ач холбогдолтой байна.

Монгол Улсын хувьд гэр бүлийн маргааныг тэр дундаа хүүхдийн асрамж болон тэтгэлэгтэй холбоотой маргааныг иргэний хэргийн шүүх харьяалан шийдвэрлэж байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн хугацаанд шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоон мэдээллийг харьцуулж үзвэл 2023 онд нийт 5913 хэрэг³⁶, 2024 онд нийт 6520 хэрэг³⁷, 2025 онд нийт 6958 хэрэг³⁸ тус тус шийдвэрлэснээс үзэхэд жил ирэх тусам нийт шийдвэрлэгдэж буй хэргийн тоо нэмэгдэж байгааг харж болно.

Өнөөгийн нөхцөлд хүүхдийг асрамждаа авсан эцэг эсхүл эх нь хүүхдийн өдөр тутмын хэрэгцээг хангаж, хүүхдийн талаар аливаа шийдвэр гаргах, хүүхдийг эрх зүйн харилцаанд төлөөлөх, улмаар хүүхдийн өмнөөс хариуцлага хүлээх хандлага давамгайлдаг бол хүүхдийг асрамждаа аваагүй эцэг эсхүл эхэд эдгээр үүрэг шууд оногдохгүй ч хүүхэдтэйгээ уулзах, харилцах нөхцөл журам нь тодорхойгүй болж, энэ нь салсан эхнэр, нөхөртэйгөө харилцаа ямар байгаагаас шалтгаалсан шинжтэй³⁹ байдгаас үзэхэд Монгол Улсын хувьд нэг талын асрамжийн хэлбэр хэрэгждэг буюу шүүхээр хүүхдийн асрамжийг тогтоолгосон эцэг эсхүл эх нь хүүхдийн ирээдүйд нөлөө бүхий шийдвэрийг дангаар гаргах үр дагаварт хүрч байна гэсэн үг юм.

Манай Улсын шүүхийн практикт хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ холбогдох зохицуулалтын хүрээнд нэг талын асрамжид үлдээх шийдвэрийг гаргах ба дийлэнх тохиолдолд хүүхдийг "эхийн асрамжид" үлдээж шийдвэрлэж буй жишиг тогтжээ.⁴⁰

³⁴ Монгол Улсын дээд шүүх, "Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл", Улаанбаатар, 2013 он, 48 дахь тал.

³⁵ Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989)-ийн 3 дугаар зүйл.

³⁶ Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн 2023 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ" 2023, <https://judcouncil.mn/>

³⁷ Шүүхийн ерөнхий зөвлөл, "Монгол Улсын шүүхийн 2024 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ" 2024, <https://judcouncil.mn/>

³⁸ Шүүхийн ерөнхий зөвлөл, "Монгол Улсын шүүхийн 2025 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ" 2025, <https://judcouncil.mn/>

³⁹ Шүүхийн академи, өмнөх эшлэл 2, 81 дэх тал.

⁴⁰ Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 192/ШШ2025/08107 шийдвэр, Говь-Алтай аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 305/ШШ2025/00647 шийдвэр, Дархан-Уул аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 307/ШШ2025/01676 шийдвэр, Ховд аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 319/ШШ2025/00677 шийдвэр, Увс аймаг дахь сум дундын



Улмаар Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1⁴¹, 26.6⁴² дахь хэсэгт зааснаар хуулиар хүлээсэн эцэг, эхийн үүрэг хэвээр үлдэхийг, уг үүргээ хэрэгжүүлэхэд нь зохигчдын хэн аль нь саад болохгүй байхыг даалгаж шийдвэрлэдэг боловч шүүхийн шийдвэрийн энэхүү хэсэг бодит байдалд хэрэгжиж байгаа эсэх нь эргэлзээ үүсгэж байна. Өөрөөр хэлбэл, хүүхдийг асрамждаа авсан эцэг эсхүл эх нь асрамждаа аваагүй эцэг эсхүл эхтэй хүүхдийг чөлөөтэй уулзуулах, хуульд заасан эцэг, эхийн хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, асран хамгаалах үүргээ хэрэгжүүлэхэд нь саад учруулах байдал гарсаар байгаагаас шалтгаалан хүүхдийн асрамжийг өөрчлүүлэхээр дахин шүүхэд маргаан үүсгэх⁴³ тохиолдол нэлээдгүй гарч байх ба энэ төрлийн маргаан цаашид нэмэгдэх хандлагатай байгаа нь дурдсан статистикаар нотлогдоно.

Түүнчлэн хүүхдийн асрамжийг авсан тал нь тухайн хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, амьдрах орчин нөхцөл, хоол хүнс, хувцас хунар, чөлөөт цаг болоод амралтыг хэрхэн өнгөрөөх зэрэг асуудлыг дангаар шийдвэрлэх, үүнтэй холбоотой гарсан (ирээдүйд гарах) зардлыг Гэр бүлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1⁴⁴ дэх хэсэгт заасан тэжээн тэтгүүлэгчид онцгой нөхцөл байдал тохиолдсон гэж үзэж, нэмэлт зардал гаргуулахаар шүүхээр нэхэмжлэх тохиолдол цөөнгүй гарч байгаа нь энэ төрлийн нэмэлт зардал нэхэмжлэх маргаан ирээдүйд ч буурахгүйг илтгэж байна. Тодруулбал, гэрлэлтээ цуцлуулснаас хойш хүүхдийн асрамжийг авсан тал нь хүүхдийг төлбөртэй сургуульд сургаж эсхүл дугуйлан секцэд хамруулж сургалтын төлбөрт төлсөн төлбөрийн тал хувийг нөгөө талаас гаргуулахаар шаардсан тохиолдолд шүүх хүүхдийг төлбөртэй сургуульд сургахаар эцэг, эх нь хоорондоо харилцан тохиролцсон эсэхийг харгалзан үзэж, уг зардлыг бодитоор гарсан байх (ирээдүйд гарах зардал буюу бодитоор зардал гараагүй байгаа тохиолдолд хангахгүй орхиж шийдвэрлэсэн) шаардлагыг тавьсан байна. Ийм нэгэн шийдвэрийн жишээг дурдвал:

анхан шатны шүүхийн 2025 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 318/ШШ2025/00614 шийдвэр.

⁴¹ Гэр бүлийн тухай хууль (1999)-ийн 26 дугаар зүйлийн 26.1 "Эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ".

⁴² Гэр бүлийн тухай хууль (1999)-ийн 26 дугаар зүйлийн 26.6 "Хүүхдийн эрх, ашиг сонирхолд харшлахааргүй бол гэрлэлтээ цуцлуулсан эцэг, эхийн хэн нэг нь нөгөөдөө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахыг хориглоно."

⁴³ Говьсүмбэр аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 306/ШШ2025/00259 шийдвэр, Дархан-Уул аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 307/ШШ2025/01127 шийдвэр, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 192/ШШ2025/05343 шийдвэр, Хөвсгөл аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 320/ШШ2025/00299 шийдвэр.

⁴⁴ Гэр бүлийн тухай хууль (1999)-ийн 48 дугаар зүйлийн 48.1 "Тэжээн тэтгүүлэгчид онцгой нөхцөл байдал тохиолдсон /хүндээр өвчилсөн, тахир дутуу болсон, эмчлүүлсэн, сургуульд орсон гэх мэт/ үед түүнд нэмэлт тэтгэлэг гаргуулах, эсхүл гарсан зардлыг хариуцуулахаар энэ хуулийн 47.2-т заасан этгээд шүүхэд нэхэмжлэл гаргаж болно."



Тохиолдол 5. Улсын дээд шүүхийн 2025 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 001/ХТ2025/00095 дугаар тогтоол⁴⁵

...Нэхэмжлэгч нь гэрлэлт цуцалснаас хойш 4 хүүхдийн сургалтын төлбөрт нийт 18.380.000 төгрөгийг төлсөн ба төлбөрийн 50 хувь болох 9.190.000 төгрөгийг хүүхдүүдийн эцгээс гаргуулахаар нэхэмжилсэн. Хариуцагч нь тайлбарлахдаа: сургалтын төлбөр бол зайлшгүй зардал биш тул хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж маргажээ. Үүнийг анхан шатны шүүхээс шийдвэрлэхдээ төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгодог байхад хувийн сургуульд хүүхдүүдийг суралцуулж байгаа нь эцэг, эхийн сайн дурын асуудал байх бөгөөд хувийн сургуульд сургасан төлбөрөө хариуцагчаас нэхэмжилж байгаа нь нэмэлт зардал гэж үзэх үндэслэлгүй гэж дүгнэсэн бол давж заалдах шатны шүүх ...хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших, хөгжиж төлөвшихөд нь туслах эцэг, эхийн үүргийн хүрээнд төлбөртэй сургуулийг сонгон суралцуулсанд нэхэмжлэгчийг буруутгах үндэслэлгүй. Иймд сургалтын төлбөрт 9.190.000 төгрөг гаргуулахаар анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн. **Хяналтын шатны шүүх ...хэдийгээр бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгодог боловч зохигч гэрлэлтээ цуцлуулахаас өмнө хүүхдүүд тухайн төлбөртэй сургуульд суралцаж байсан, төлбөрийг гэр бүлийн орлогоос төлж байсан тул хүүхдүүдийг төлбөртэй сургуульд сургахаар эцэг, эх нь харилцан тохиролцсон байсан гэж үзнэ.**

Мөн Гэр бүлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасан "тэжээн тэтгүүлэгчид онцгой нөхцөл байдал тохиолдсон" гэдэгт хүүхдийн төлбөртэй сургуульд суралцсан төлбөр, дугуйлан, сургалтын төлбөр, эмчилгээний зардал зэргийг хамааруулахаас гадна хүүхдийн амьдарч буй үл хөдлөх хөрөнгийн түрээсийн зардлыг⁴⁶ нэмэлт зардалд тооцож, эцэг, эх уг зардлыг хамтран хариуцах үүрэгтэй гэж шийдвэрлэжээ.

IV. ДҮГНЭЛТ

"Гэр бүл" гэдэг нь нийгмийн анхдагч нэгжээр үл барам гэр бүлийн харилцаа нь нийгмийн анхдагч харилцааны нэгд зүй ёсоор тооцогдог тул гэр бүлээс улбаатай хүүхэд, цаашилбал хүүхдийн асрамж, эцэг, эхийн хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг нь хүүхдийг эрүүл өсөж бойжих, цаашилбал бие хүн болон хүмүүжин төлөвших нөхцөл нь "гэр бүл" гэх ойлголттой салшгүй нягт холбоотой билээ.

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээр хүүхдийн асрамж, түүний төрөл, төрөл бүрийн давуу болон сул тал, эцэг, эх нь хүүхдээ тэжээн тэтгэх харилцаатай холбоотой бусад гадаад улсын жишиг, хууль зүйн нэр томъёоны хувьд бий болж буй "тренд", шүүхийн практик зэргийг дэлгэрүүлэн судаллаа.

Судалгаанаас дүгнэхэд, Монгол Улсад Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулахад, тэр дундаа тус шүүхийн харьяалан шийдвэрлэх гэрлэлт цуцлалттай холбоотой маргаанаас гадна орхигдуулж үл болох, нэн тэргүүнд зайлшгүй анхаарах, цаашид гүнзгийрүүлэн судалбал зохих, гэр бүлийн эрх зүйн

⁴⁵ Шүүхийн шийдвэрийн цахим сан: https://shuukh.mn/single_case/10835?daterange=2025-01-01%20-%202026-03-20&id=3&court_cat=1&bb=1c

⁴⁶ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 210/МА2023/00957 магадлал.



маргааны төрлийн хэмжээнд авч үзэх ёстой асуудал нь хүүхдийн асрамж болон эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой асуудал байна.

Учир ийм тул, хүүхдийн асрамж тогтоох асуудлыг гэрлэлт цуцлалтын дагалдах асуудал төдийхнөөр хязгаарлан авч үзэх бус дагнасан шүүхийн харьяалан шийдвэрлэх бие даасан маргааны төрлийн түвшинд авч үзэх нь "зөв бөгөөд хүнлэг" шүүхийн практик төлөвшүүлэхэд ихээхэн ач холбогдолтойн дээр Япон Улсын жишгээр Монгол Улсад Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулах эрх зүйн орчин нэгэнт бүрдэн, тус шүүх үйл ажиллагаагаа явуулж эхлэх цаг "төд удалгүй" тохиох тул шүүхээс хэрэг маргааныг шийдвэрлэхдээ "хүүхдийн дээд ашиг сонирхол"-ыг заавал харгалзан үзэх шаардлагатай.

Ингэхдээ Гэр бүлийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулга болоод Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслүүдэд холбогдох зохицуулалтыг хууль дээдлэх ёс (rule of law)-ны индексээр эхэнд эрэмбэлэгддэг эрх зүйн соёл, ухамсар эрт дээр үеэс төлөвшин тогтсон улсуудын эрх зүйн зохицуулалтыг "сохроор дагаж хуулбарлан хуульчлах" бус өөрийн орны эрх зүйн соёл, уламжлал, сэтгэлгээний онцлогт тулгуурлан хуульчлах хэрэгцээ нэгэнт бий болжээ гэж үзсэн болно. Түүнчлэн эрх зүйн зохицуулалтыг хуульчлах, шүүхийн сайн практикийг судлан хөрсөндөө буулгахдаа бусад гадаад улсын сайн жишгийг сайтар судалж хөгжингүй улсуудтай хөл нийлүүлэн алхахыг зорихоо урьтал болгох бус "эрх зүйн хөгжлөөс хойш суухгүй байх" зорилгыг хэрэгжүүлбэл зохилтой.

Хүүхдийн асрамжийг тогтоох үндсэн хоёр хэлбэр буюу нэг талын асрамж, хамтарсан асрамжийн аль аль нь давуу болон сул талтай боловч судлаачдын зүгээс "сайн жишиг"-ээр Япон Улсын хэрэгжүүлж эхлэх гэж байгаа буюу "хосолмол хэлбэрийн, сонгох боломжит" асрамжийн хэлбэрийг хуульчлахыг "зохистой" гэж үзсэн болно. Учир нь энэхүү хэлбэр нь нэг талын болон хамтарсан асрамжийн давуу болон сул талыг нөхөх шинжтэй буюу цаг алдалгүй хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргах, эцэг, эх шаардлагатай тохиолдолд зөвшилцөн шийдвэр гаргах боломжийг цогцоор нь хангасан юм. Хэдий энэхүү хосолмол хэлбэрийн сонгох боломжит хүүхдийн асрамжийн системийг хэрэгжүүлснээр ирээдүйд шүүхийн практикт үзүүлэх нөлөөг урьдчилан таамаглахад бэрх боловч нэг талын эсхүл хамтарсан асрамжийн аль нэгийг хуульчилснаас үүсэх сөрөг үр нөлөөг тодорхой хэмжээнд бууруулан удирдах боломж бүрдэх юм.

V. САНАЛ

Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл хэлэлцэгдэж, Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулагдах гэж байгаатай холбогдуулан хүүхдийн асрамжийн хэлбэр, эцэг, эхийн хүлээх хариуцлага (нэг талын асрамж, хамтарсан асрамж)-ыг нарийвчлан зохицуулах буюу хүүхдийн асрамжийг эцэг эсхүл эх ганцаараа хэрэгжүүлэх тохиолдолд эцэг, эх ямар эрх, үүрэгтэй оролцох, хамтарсан асрамжийг хэрэгжүүлэх боломжийг хуульчлах эсэхийг холбогдох хуулиар



нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Түүнчлэн хүүхдийг тэжээн тэтгэх үүргийг эцэг, эхэд хэрхэн хуваарилах, Гэр бүлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасан "тэжээн тэтгүүлэгчид онцгой нөхцөл байдал тохиолдсон" гэдгийг илүү дэлгэрэнгүй байдлаар зохицуулж, эцэг, эхийн үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргийг нэг мөр ойлгох нь цаашид шүүхийн практикт сайн жишиг тогтооход чухал ач холбогдолтой хэмээн үзэж судлаачдын зүгээс дараах саналын дэвшүүлээ:

1. "Хүүхдийн асрамж" гэх ойлголтын агуулга, хамрах хүрээ хуульд тодорхой тусгагдаагүйгээс асрамжийн эрхийн хүрээнд ямар асуудлыг шийдвэрлэх, эцэг, эхийн эрх, үүрэг хэрхэн хэрэгжих талаар ойлголтын зөрүү үүсэх боломжтой байх тул Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн хуулийн нэр томьёо хэсэгт "хүүхдийн асрамж" гэх албан ёсны нэр томьёог тодорхойлох,
2. Япон Улсын жишгээр асрамжийн хэлбэрийг сонгох боломжтой байхаар хуульд тусгах, ингэснээр хүүхдийг асрамждаа авсан талын шийдвэрээр нөгөө талд эдийн засгийн болоод сэтгэл зүйн дарамт, хүндрэл учруулахаас зайлсхийх боломж бүрдүүлэх,
3. Хүүхдийн асрамжтай холбоотой зохицуулалтыг хуульд илүү боловсронгуй болгож, эцэг, эхийн шийдвэр гаргах эрх, үүргийн хуваарилалт (хүүхдийн өмнөөс чухал шийдвэр гаргах, хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, хариуцлага хүлээх гэх мэт)-ыг нарийвчлан зохицуулснаар цаашид шүүхийн практикийг нэг мөр болгох, гэр бүлийн маргааныг "хүүхдийн дээд ашиг сонирхол"-д нийцүүлэн шийдвэрлэх эрх зүйн үндсийг бэхжүүлэх ач холбогдолтой,
4. Хүүхдийн "хамтарсан асрамж"-ийн хэлбэрийг илүү нарийвчлан судалж, цаашид хөгжүүлэх, Монгол Улсын эрх зүйн тогтолцоо, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, гэр бүлийн харилцаа зэрэгт нийцүүлэн хуульчлах боломжтой эсэхийг судлах. Энэ нь хүүхдийг асрамждаа аваагүй эцэг эсхүл эх хүүхэдтэй холбоотой аливаа шийдвэр (сурч боловсрох, амьдрах орчин нөхцөл, хүмүүжил, оршин суух газар гэх мэт) гаргахад оролцож, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, асран хамгаалах эрх, үүргээ хэрэгжүүлэхэд адил эрх эдлэх боломжийг бүрдүүлэхээс гадна хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах олон улсын зарчимд нийцнэ.



НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 он.
2. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль, 1999 он.
3. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016 он.
4. Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 2024 он.
5. Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2024 он.
6. Монгол Улсын дээд шүүхийн Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай зөвлөмж, 2007 он.
7. Монгол Улсын дээд шүүхийн "Гэр бүлийн холбогдолтой эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудал" зөвлөмж, 2017 он.
8. Монгол Улсын дээд шүүх, "Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл", 2013 он.
9. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 192/ШШ2025/08107 шийдвэр,
10. Говь-Алтай аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 305/ШШ2025/00647 шийдвэр,
11. Дархан-Уул аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 307/ШШ2025/01676 шийдвэр,
12. Ховд аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 319/ШШ2025/00677 шийдвэр,
13. Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 318/ШШ2025/00614 шийдвэр.
14. Говьсүмбэр аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 306/ШШ2025/00259 шийдвэр,
15. Дархан-Уул аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 307/ШШ2025/01127 шийдвэр,
16. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 192/ШШ2025/05343 шийдвэр,
17. Хөвсгөл аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 320/ШШ2025/00299 шийдвэр.
18. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 210/МА2023/00957 магадлал.

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Хууль зүй, дотоод хэргийн яам, "Шүүх, эрх зүйн шинэчлэлт" төсөл, Гэр бүлийн эрх зүй /гарын авлага/, 2007 он.
2. Шүүхийн академи, Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр



бүл, 2025 он.

3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. Civil Code of Japan, 1896.
2. Divorce Act of Canada, 1985.
3. Jordan v. Rea, 2009.
4. Roe v. Roe, 1985.
5. Barb Lightner, Child Custody, 2025.
6. Jeff Atkinson, Custody: It all comes down to the best interest of the child, Family Advocate, Vol. 12, No. 3, 1990.
7. Maria Cancian, Daniel R. Meyer, Who Gets Custody?, Demography, Vol. 35, No. 2, 1998.
8. Mary Ann Mason, From Fathers' Property to Children's Rights: A History of Child Custody, University of California, Berkeley School of Law, 1994.

4. Цахим эх сурвалж

1. Монгол Улсын Дээд шүүхийн цахим хуудас: <https://www.supremecourt.mn/>.
2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/>.
3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас: <https://judcouncil.mn/>.
4. Шүүхийн шийдвэрийн цахим сан: <https://shuukh.mn/>.
5. JSTOR цахим сан: <https://www.jstor.org/>.
6. Cision мэдээллийн сайт: <https://news.cision.com/>.
7. EBSCO судалгааны платформ: <https://www.ebsco.com/>.
8. Канад Улсын Засгийн газрын цахим хуудас: <https://www.justice.gc.ca/>.
9. Justia хууль зүйн мэдээллийн сайт: <https://law.justia.com/>.
10. FindLaw хууль зүйн мэдээллийн сайт: <https://caselaw.findlaw.com/>.
11. Durham Asian Law Journal цахим хуудас: <https://www.durhamasianlawjournal.com/>.
12. Savvy Tokyo цахим хуудас: <https://savvytokyo.com/>.
13. Japan Policy Forum цахим хуудас: <https://www.japanpolicyforum.jp/>.
14. Nejihashi цахим хуудас: <https://nejihashi.com/>.
15. Japan Today мэдээний сайт: <https://japantoday.com/>.
16. Note.com сайт: <https://note.com/>.



Article

Бүтээл
Хүснэгт
Таблица

Comparative perspectives on child custody and child support: Legal issues, recent trends and judicial resolution of family disputes

BYAMBA-OD Dorjtovoo*

ANKHBAYAR Otgon**

Abstract: In Mongolia, the Appellate Court for Family and Child Cases and the Circuit court for Family and Child Cases of the Capital city is going to be established pursuant to Article 1.3, 2.4, respectively, of the Law on Establishment of Courts (Revised edition) enacted on June 5, 2024.

Although the law mandated the formal establishment of these courts on January 1, 2026, they have not yet commenced operations as of March 2026 due to challenges concerning the legal environment, economy, infrastructure, and human resources.

This research paper examines Mongolia's legal regulations and judicial practices regarding "child custody and parental child support obligations," as governed by the Convention on the Rights of the Child, the Law on Family (1999), and the Law on Child Rights (2016). Furthermore, it identifies and compares the legal frameworks, distinct characteristics, and future development trends of other jurisdictions within this scope. Based on this analysis, the paper addresses key issues to consider for the future resolution of such disputes by specialized courts, and proposes corresponding conclusions and recommendations.

Keywords: family court, child custody (sole custody, joint custody), child maintenance, parenting time, decision making.

* Head of the Civil law sector of Judicial academy under the Supreme court of Mongolia, Master of Public Administration (MPA).

** Researcher of the Civil law sector of Judicial academy under the Supreme court of Mongolia, Lawyer.